



**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газар /Д.Дэлгэрсайхан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/146 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Doctushaal Said. 2020

151600009

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021
оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 1/02
дугаар тушаалын хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНД
МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ХАДГАЛАХ, ТҮҮНИЙ
АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан улсын бүртгэгчийн хүлээх үүрэг болон үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах харилцаанд Улсын бүртгэлийн багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн акт болон энэ журмыг баримтална.

1.3. Улсын бүртгэлийн байгууллагын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж нь улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах чиглэлээр Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

1.4. Нэгдсэн ангилал, код, индекс арга зүй, стандарт, баримт бичгийн шаардлага болон хуульд заасны дагуу цуглуулж, боловсруулж, хадгалсан иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн бүрдлийг цахим мэдээллийн сан /цаашид "Цахим мэдээллийн сан" гэх/ гэнэ.

1.5. Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийг холбосон шилэн кабелин дэд бүтцийн урсгалыг мэдээллийн нэгдсэн сүлжээ /цаашид "мэдээллийн нэгдсэн сүлжээ" гэх/ гэнэ.

1.6. Цахим хэлбэрийн өгөгдөл, мэдээлэл хүлээн авах, цуглуулах, дамжуулах, хадгалах, сэргээх, боловсруулах, гаргах үйл ажиллагааны нэгдлийг мэдээллийн систем /цаашид "мэдээллийн систем" гэх/ гэнэ.

1.7. Хэрэглэгчийн компьютерт зөвшөөрөлгүйгээр нэвтрэх чадвартай, компьютерийн ачааллыг хуурамчаар нэмэгдүүлэн, гацалт үүсгэх, компьютерт гаднаас халдах хандалт нээж өгөх, түүний хэвийн үйл ажиллагааг тасалдуулах зорилготой үйлдлийг хийдэг программ хангамжийг хортой код /цаашид "хортой код" гэх/ гэнэ.

Хоёр. Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах

2.1. Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, өөрчлөх, боловсруулах, баталгаажуулах, хадгалах ажлыг улсын бүртгэгч эрхлэн гүйцэтгэнэ.

2.2.Улсын бүртгэгч цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авахдаа иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бүртгэл хөтлөх журмыг тус тус баримтална.

2.3.Улсын бүртгэгчид цахим мэдээллийн санд нэвтрэх эрх олгох, эрхийг цуцлах асуудлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрийг үндэслэн мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн нэгжээс нууцын баталгаа гаргуулж, олгоно.

2.4.Улсын бүртгэгч цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авахдаа өөрт олгогдсон эрхийг ашиглан холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зөвхөн улсын бүртгэлийн байгууллагаас зөвшөөрөгдсөн програм хангамж, техник, тоног төхөөрөмжийг ашиглан эх нотлох баримт бичигт үндэслэж, үнэн зөв оруулна.

2.5.Улсын бүртгэгч цахим мэдээллийн санд хүлээн авсан иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн үнэн зөвийг эх нотлох баримттай тулгалт хийн баталгаажуулж, хадгална.

2.6.Цахим мэдээллийн санд хүлээн авч, хадгалсан иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээлэлд шүүхийн шийдвэр, улсын ерөнхий байцаагчийн шийдвэр, хяналтын улсын ахлах байцаагч болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн улсын ахлах бүртгэгч эсхүл улсын бүртгэгч засвар, өөрчлөлтийг хийнэ.

Гурав.Цахим мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах

3.1.Улсын бүртгэгч мэдээллийн аюулгүй байдал, шинэ технологи, програм хангамж, техник, тоног төхөөрөмжийн талаарх сургалтад хамрагдах бөгөөд цахим мэдээллийн сангийн сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах анхан шатны мэдлэгтэй байна.

3.2.Цахим мэдээллийн санд холбогдсон компьютерийн дэлгэцийг бусад этгээдэд шууд харагдахгүй байхаар байрлуулсан байна.

3.3.Цахим хэлбэрийн өгөгдөл, мэдээллийг хадгалах зориулалт бүхий зөөврийн хадгалах төхөөрөмжийг компьютерт холбох тохиолдолд хортой код /хэрэглэгчийн компьютерт зөвшөөрөлгүйгээр нэвтрэх чадвартай, компьютерийн ачааллыг хуурамчаар нэмэгдүүлэн, гацалт үүсгэх, компьютерт гаднаас халдах хандалт нээж өгөх, түүний хэвийн үйл ажиллагааг тасалдуулах зорилготой үйлдэл хийдэг програм хангамж/-оос хамгаалах программ уншуулсан байна.

3.4.Цахим мэдээллийн санд нэвтрэхэд дараах шаардлагыг хангасан нууц үгтэй байна:

3.4.1.том, жижиг үсэг, тоо, тусгай тэмдэгтийг хослуулах;

3.4.2.үүсмэл үг үүсгэх;

3.4.3.эргэн санахад хялбар байхаар логик дараалалтай байх.

3.5.Цахим мэдээллийн санд нэвтрэх нууц үг үүсгэхэд дараах зүйлсийг хориглоно:

3.5.1.өөрийн болон гэр бүлийн гишүүний нэр, тэдгээрийн төрсөн он, сар, өдөр, утасны дугаар, машины дугаар зэрэг бусад этгээд мэдэж байж болзошгүй мэдээллийг ашиглах;

3.5.2.цахим мэдээллийн санд нэвтрэх хэрэглэгчийн нэрийг давтах;

3.5.3.өмнө хэрэглэж байсан нууц үгийг дахин хэрэглэх;

3.5.4.нийтлэг хэрэглэгддэг, таах боломжтой, дан буюу дараалсан, тэгш хэмтэй тоо, үсэг /asd, aabbcc, 1234, 1111, 123456, aaa гэх мэт/ хэрэглэх.

3.6.Улсын бүртгэгч компьютерийн үйлдлийн системийн нууц үгийг сард нэг удаа, цахим мэдээллийн санд нэвтрэх нууц үгийг улиралд нэг удаа солино.

Дөрөв.Улсын бүртгэгчийн эрх, үүрэг

4.1.Улсын бүртгэгч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Цахим мэдээллийн санд нэвтрэх, хүлээн авах, өөрчлөх, боловсруулах, баталгаажуулах, хадгалах;

4.1.2.шаардлагатай тохиолдолд тухайн нэгжийн мэдээллийн технологийн ажилтанд мэдэгдэн зохих үйлчилгээ, заавар, зөвлөгөөг авах;

4.1.3.Цахим мэдээллийн сангийн аюулгүй байдалтай холбоотой аливаа зөрчлийг мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгжид тухай бүр мэдэгдэх;

4.1.4.Цахим мэдээллийн санд холбогдсон компьютерийн нэр, сүлжээний нэрийг солихгүй байх;

4.1.5.Цахим мэдээллийн сан, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах талаар мэдээллийн технологийн ажилтнаас өгсөн шаардлагыг биелүүлэх.

Тав.Хориглох зүйл

5.1.Улсын бүртгэгчид дараах зүйлсийг хориглоно:

5.1.1.Цахим мэдээллийн санд бүртгэгдсэн Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцад хамаарах аливаа мэдээллийг бусдад задруулах, түүнчлэн аливаа зорилгоор өөртөө ашиглах;

5.1.2.Цахим мэдээллийн санд нэвтрэх нууц үгийг ил бичиж, тэмдэглэх, дамжуулах, нэвтрэх эрхийг бусдад шилжүүлэх;

5.1.3.Цахим мэдээллийн санд холбогдсон компьютерт албан хэрэгцээнээс бусад программ хангамж суулгах;

5.1.4.Цахим мэдээллийн санд энэ журамд заасан зорилгоор иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хийхээс бусад зорилгоор хандалт хийх;

5.1.5.ажлын өрөө солих, байрлалаа солих, шилжүүлэх тохиолдолд сүлжээний тохиргоог зөвшөөрөлгүй өөрчлөх;

5.1.6.Цахим мэдээллийн санд холбогдсон компьютерт шаардлагагүй тохиолдолд дундын хавтас нээх, мэдээллийн нэгдсэн сүлжээнд нээсэн дундын хавтас дахь мэдээ, өгөгдлийг удаан хугацаагаар хадгалах;

5.1.7.мэдээллийн нэгдсэн сүлжээ /улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтэс, тасгийг холбосон шилэн кабелин дэд бүтцийн урсгал/-нд холбогдсон бусад компьютер доторх дундын хавтас дахь материалыг устгах.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.